



MONGOLICA

AN INTERNATIONAL JOURNAL OF MONGOL STUDIES

Vol. 46, 2013



MONGOLICA

AN INTERNATIONAL JOURNAL OF MONGOL STUDIES

Vol. 46, 2013

Secretariat of the International
Association for Mongol Studies

Ulaanbaatar

INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES

President	Klaus Sagaster (Germany)
Honorary President	Ozawa Shigeo (Japan)
	Bira Sh (Mongolia)
Vice-Presidents	Bazarov B.V (Russia)
	Bawden Ch (UK)
	Chingeltei (PRC)
	Choi Kee Ho (Korea)
	Enkhtuvshin B (Mongolia)
	Humphrey C (UK)
	Tumur-Ochir S (Mongolia)
	Schwarz H.G (USA)
Secretary-General	Tumurtogoo D (Mongolia)
Executive Director	Ishdorj Ts (Mongolia)

The International Association for Mongol Studies (IAMS) is an International non-governmental scholarly organization uniting Mongolists, Centres of Mongol studies and Associations on a voluntary basis

The IAMS aims at encouraging Mongol studies, assisting scholarly activities of Mongol study Centres and Scholars Mongolists, promoting mutual understanding and cooperation among scholars from different countries of the world (from the IAMS Constitution).

This “Mongolica” was prepared by the IAMS Secretariat

Editor-in-chief	Tumurtogoo D.
Executive Secretary	Purevjav E.
Technical Editor	Altantsetseg M, Battulga M.
Computer Typist	Narantuya Ch.

Editorial Address: Sukhbaatar Square-3
Ulaanbaatar-11, P.O. 20A
Mongolia
Office of the IAMS Secretariat
E-mail: iams@magicnet.mn
Phone/Fax: 976-11-261328
Phone: 976-11-262553, 262491

The views expressed in the materials, contributed for the “Mongolica” are those of the individual authors and do not necessarily reflect views of the Editors or the IAMS Secretariat

ГАРЧИГ

I. Монгол судлалын өгүүлэл

Ван Хао (БНХАУ). Ц.Дамдинсүрэн ба XX зууны Монголын утга зохиолын судлал шүүмжлэл	7
Окада К (Япон). Г.Жигжидсүрэнгийн найруулсан “Их Нацагдорж” баримтат - уран сайхны киноны тухай	13
Пүрэвжав Э (Монгол). Монгол хэлний хэм хэмжээ судлал	20
Ринчиндорж Ж (БНХАУ). “Бэнсэн”-ий үлгэрийн тухай	35
Цендина А.Д (ОХУ). Сургаалын зохиолын уламжлал шинэ уран зохиолд	50
Цэрэнсодном Д (Монгол). Тэнгэрийн орон “LI YUL”-ийн тухай	52
Чулуун С (Монгол). Шинжлэх ухааны хүрээлэн дэх Л.Дэндэвийн жилүүд	57
Лиштованный Е.И (Россия). Становление и развитие науки о Монголии в Восточной Сибири (XVIII-XIX вв)	80
Очир А (Монголия). Прототип и происхождение названия Мангаса (MANGYUS) главного героя в монгольском фольклоре	88
Obrusānszky Borbála (Hungary). Cult of the Sun Hunnish and Mongolian Connections	94

II. Эрдэм шинжилгээний өгүүлэл

Акира Камимүра (Япон). Алтайн урианхайчууд: Монголын социалист угсаатны зүйн онолд	103
Дагвадорж Д (Монгол). Монголын ба даян дэлхийн тогтвортой хөгжил: түүхэн үйл явц, сургамж, дүгнэлтүүд	111
Жиан Чуан (БНХАУ). Чингис хаан Чихургу уулын хөндийн их замын сургаалын ээдрээтэй асуудлын тайлбар	119
Мөнхбаяр Б (Монгол). XX зууны төгсгөл, XXI зууны эхэн үеийн Монголын уран зохиолын судлал шүүмжлэлийн товчоо (1990-2007)	124

Мягмарцэрэн Ш (<i>Монгол</i>). Нарны арал, цагаан арал, үзэсгэлэнт арлыг олохоор хийсэн судалгаа үр дүн	148
Отгонцэцэг Д (<i>Монгол</i>). Солонгос, Монгол иргэдийн гэрлэлтийн өнөөгийн байдал, хэтийн төлөв	158
Содбаатар Ж (<i>БНХАУ</i>) “Бөрт чоно”-ын тухай эндүүрэл	172
Ууганбаатар Ж (<i>Монгол</i>). Монголын орчин үеийн жүжгийн зохиолын туурвил зүйн чиг хандлага (1990-2010 оны жишээн дээр)	177
Дробышев Ю.И (<i>Россия</i>). Кто научил Монголов поклоняться небу?	180
Панов А.И (<i>Россия</i>). Современная интеграция Российского образования в Монголию	195
Тагарова Т.Б (<i>Россия</i>). К семантико-когнитивному анализу концепта “язык” бурятского языка	201
Фалилеева Н.В., Филин С.А., Дугаржав Л., Ерофеева И.А (<i>Россия</i>). Проблемы взаимодействия России и Монголии в сфере образования	207
Zolzaya Choijin (<i>Mongolia</i>). The cultural basis of the body is a container Metaphor in English and Mongolian	225

III. Мэдээлэл

Эмгэнэл. Профессор Чингэлтэй (1924-2013)	239
---	-----

II. ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ
ӨГҮҮЛЭЛ

АЛТАЙН УРИАНХАЙЧУУД: МОНГОЛЫН СОЦИАЛИСТ УГСААТНЫ ЗҮЙН ОНОЛД

Акира Катимүра (Япон)

Одоо Алтайн Урианхайг баруун Монголын бага ястануудын нэг гэж үздэг. Гэвч энэ “ястан” гэдэг үгийг “яс (эцгийн талын удам угсаа) эсвэл гарал үүсэл нэгтэй бүлэг хүмүүс” гэж ойлговол Алтайн Урианхайн үнэн байдалтай нийцэхгүй болно. Ер нь одоогийн Монголын ястануудын ихэнх нь Чин улсын засаг захиргааны нэгж байж сүүлд улс төрийн шалтгаанаар юм уу, угсаатны зүйн хувьд “ястан” гэдэг статусыг олсон юм. Энэхүү өгүүлэлд би “ястан” гэдэг статус Алтайн Урианхайн хувь заяанд ямархуу нөлөөлсөн тухай тодорхойлно.

“Ястан” бол “национальность”, “народность”-ийг орчуулсан нэр томъёо мөн бөгөөд марксизмын угсаатны онолтой шууд холбоотой үүссэн үг болно. 19-р зууны үед Darwin-ы хувьсалын онолоос санаа авсан L.H.Morgan-ий зохиосон “Эртний нийгэм” нь Маркс, Энгельс нарыг үзэл санаагаа боловсруулахад их нөлөөлсөн гэдэг. Энэ нь H.Spencer-ийн нийгмийн хувьсалын онолын (Social Darwinism) нэг хувилбар гэж үзэж болно. Иймэрхүү үзэл нэг нийгмийг амьд биетийн ген шиг урт удаан хугацаанд бие дааж үргэлжилсэн, тухайн цаг үеийн нөхцлийг дагаж хувьсан хөгжиж ирсэн гэж үздэг.

Монголын социалист угсаатны онолын хувьд ч “ястан”-ыг угсаа гарал нэгтэй хүмүүсийн бүлэг бөгөөд капитализм болон социализмын үед ижилсэх, уусан шингэх явцанд нийлж үндэстнийг бүрэлдүүлнэ гэж үздэг байсан (Бадамхатан 1882). Одоо “ястан”-ыг англи хэлний “ethnicity”-тэй дүйцэх нэр томъёогоор хэрэглэдэг боловч “яс угсаа нэгтэй” гэсэн далд санаа нь хэвээрээ үлдсэн байна.

Дашрамд хэлэхэд өрнөдийн социологийн хувьд “ethnicity”, “nation” гэдэг ойлголтын талаар 70-аад оноос хойш нэлээн хөгжиж, “гарал үүсэл нэгтэй бүлэг хүмүүс” гэсэн хуучин төсөөлөл өөрчлөгдсөн байна. Түүгээр үл барам “хэл, нутаг дэвсгэр, эдийн засгийн амьдрал, соёлын нийтлэг шинж” (Сталин 1913) гэх мэт бодитой онцлого шинжээс субъектив хүчин зүйл болох угсаатны ухамсар (этническое самосознание) нь чухал гэж үздэг болсон бөгөөд “ethnic group”-ийг гаднаас тусгаарлагдсан (isolated) бөгөөд хөдөлгөөнгүй (static) байдлаар бус бусад бүлгүүдтэй харилцан өөрчлөгдөх хөдөлгөөнтэй (dynamic) байдлаар үздэг болсон юм.

Энд “үндэстэн”, “үндэсний үзэл”-ийн талаар 80-аад оноос хойш гарч ирсэн нөлөө бүхий гол гол санаануудыг дурдахад, Gellner ‘nationalism’ бол ‘nation’ (үндэстэн), ‘state’ (улс) хоёр нийцэх ёстой гэж үздэг үзэл санаа мөн гэдэг тодорхойлолт дэвшүүлсэн бол Anderson одоогийн дэлхийн аливаа улс 18-19-р зууны үед европд үүссэн ‘nation-state’-ийн хэдхэн хувилбарыг хуулж загвар болгон ашигласан гэж олон жишээгээр дүгнэснээс гадна хүмүүсийн дунд нэг үндэстэн гэсэн нийтлэг ухамсар бүрдэхэд орчин үеийн хэвлэл (сонин,

ном), радио телевиз гэх мэт ‘mass media’ чухал үүрэг гүйцэтгэдэг гэж бичсэн байна. Hobsbawm (1983) одоо нэг улсад багтаж яваа хүмүүсийг нэгдэх зэрэг зорилготойгоор ашиглаж байгаа янз бүрийн “уламжлалууд”-ын олонх нь хүмүүс төсөөлж байгаа шиг эртнийх биш, харин харьцангуй орчин үеийн ‘зохиомол’ (invented) уламжлал мөн гэдгийг тодорхойлсон юм.

Ингэхэд “үндэстэн”, “үндэсний үзэл” нь орчин үеийн “бүтээгдэхүүн” мөн болно. Энэ нь Бадамхатан “үндэстэн нь түүхийн тодорхой үе, тухайлбал феодалын бутралыг устгасан хөрөнгөтний нийгмийн үед буй болдог” (1982:9) гэж бичсэнтэй адил боловч Бадамхатан марксизмын үйлдвэрлэлийн хэв маягийн дэвшил юм уу, нийгмийн хувьслын онолыг үндэслэдэг бол Anderson (1991) технологийн дэвшилээр мэдээлэл дамжуулдаг ‘media’ хөгжиж хүмүүсийн ертөнцийг үздэг үзэл, нийгмийн ухамсарыг өөрчилдөг гэдэг ‘media’-гийн онолыг үндэслэдгээс ялгаатай юм. Тухайлбал сонин, ном зэрэг ‘хэвлэл’ бол улс дотор ямар нэг газарт нэг сонин, ном уншиж байгаа өөртэй төстэй хүн байгаа гэсэн ухамсар бүрдүүлдэг гэдэг.

Эдгээр үзэл бол XX зууны Монголын түүхэнд харин ч их таарч байна. ‘Nation-state’ байгуулах явцад Монголын түүхийг авч үзэхэд түүний туулсан социализмын улсын түүх нь ‘nation-state’ байгуулах түүхэн явцын нэг хувилбар болон бусад орнуудын жишээтэй харьцуулах боломж бий болох юм.

Би Алтайн урианхайн жишээн дээр, нэгдүгээрт бүлэг хүмүүсийг угсаатан, ястаны үүднээс авч үзэх угсаатны зүйн арга барилын үр нөлөөг үнэлээд, хоёрдугаарт хорьдугаар зууны эхний хагаст “ястан” болсон Алтайн урианхайчууд орчин цагийн угсаатаны явц, тухайлбал “улс-үндэстэн” (nation-state) байгуулах явцад яаж явсныг илэрхийлнэ.

1. Монголын угсаатны зүйн онол, судалгаа дахь Алтай Урианхайчууд

Монголын угсаатны зүйн зорилго нь ястнуудын гарал үүслийг тодруулахаас гадна тэдгээрийн эд, оюуны соёлыг дүрслэхэд оршдог. Тэгэхдээ “XIX-XX зууны зааг” үеийн тусгаарлагдсан нутаг дэвсгэр дээр, өөрөөр хэлбэл “угсаатны зүйн тусгай цаг-орон зайн” (ethnographical space-time) дээр сэргээн зохиодог. Иймээс тухайн бүлэг хүмүүсийг зах зээлийн эдийн засаг гэх мэт орчин үе болон гадаадын нөлөөнд үл автагдаагүй, садан төрлийн хэлхээтэй, орчин үеэс өмнөх хүмүүс болгож тэдгээрийн “цэвэр” өвөрмөц шинжийг тодруулах арга байсан бөгөөд Алтайн Урианхайн хувьд ч хятад худалдаачдын үйл ажиллагаа болон бүлэг доторхи ялгааг үл тоомсорлоход хүрсэн юм.

Уг нь Алтайн Урианхайчуудын яс угсаа буюу гарал үүслийн тухай шийдэхэд тун хэцүү болно. Алтан-Оргил (1990) “урианхай” гэдэг нэрийг зүүсэн аймгуудыг дөрвөн зүйлээр ангилсан юм. Үүнд:

1) “ойн урианхай” эсвэл “талын урианхай”-гаас гарал үүсэлтэй гэдэг нь тодорхой жинхэнэ урианхайчуудаас бүрэлдсэн аймаг,

2) захирагч нь урианхай язгууртан болохоор урианхай нэртэй болсон аймаг,

3) улс төрийн хараат харилцаанаас болж “урианхай” гэж нэрлэгдсэн буюу нэр төрийн төлөө өөрийгөө “урианхай” гэж худлаа танилцуулсан аймаг,

4) захирагдсан хүмүүс урианхай болохоор захирагч нь өөрийгөө “урианхай” гэж нэрлэдэг болсон аймаг болно¹.

Алтайн урианхайн “Мэйрэнгийн хошуу”-ны хувьд дээрх хоёрдугаар зүйлд орно. Ер нь одоогийн “ethnicity” гэдэг ойлголтоор бол нэгдүгээр зүйлийн үзэгдэл нь ховор харин бусад гурав нь энгийн, түгээмэл үзэгдэл болно. Иймээс нэг нэртэй болохоор угсаа гарал нэгтэй гэж үзэж болохгүй юм.

“清史稿” (Чин улсын түүх) зэрэг сурвалж бичигт тэмдэглэсэнчлэн Зүүнгарын харьяат байсан урианхайчууд тэнгэрийн тэтгэсний 18 оноос зайсанууд (захирагчид) нь харьяат хүмүүсээ дагуулан бүлэг бүлгээрээ Чин улсад дагаар орж мөн тэнгэрийн тэтгэсний 27 онд (1762) зүүн гарын 4 хошуу, баруун гарын 3 хошуутайгаа Алтайн Урианхайн долоон хошуу байгуулагдсан. Зүүнгар хаант улсын зайсан байсан долоон хошууны бүгдийн даргын дотор урианхай язгуурын захирагч Мэйрэнгийн хошууны Чулуун нэг л байсан бололтой.

Үүний талаар “Монгол улсын илтгэл шастир”-ын Алтайн Урианхайн Зүтгэлт гүн Цагаанбилэгийн хэсэгт:

“Уг өвөг язгуурын түшмэл байгуулсан Чулуун (赤倫), Алтай урианхайн хүн, Чин улсын тэнгэрийн тэтгэсний арван наймдугаар онд үе улиран мэйрэнгийн занги тохоон тавьжээ” (уү ebüge įjaγur-un tūšimel baiγūluγsan cilayun, altai uriyangqai-yin kümün, cing ulus-un tegri-yin tedgügsen-ü arban naimaduγar on-du üy-e ularin meγirin-ü janggi toqoγan talbijuqui) гэж Чулууныг Алтай урианхайн хүн гэж бусад бүгдийн даргаас онцгойлон тэмдэглэсэн нь түүнийг нотлох баримт болно.

Хүснэгт 1.

Алтайн урианхайн долоон хошууны бүтэц

Зүүн гар			Баруун гар		
Хошууны нэр	Ноёны цол, нэр (20-р зууны эхний үеэр)		Хошууны нэр	Ноёны цол, нэр (20-р зууны эхний үеэр)	
Зүүн амбаны хошуу	Итгэмжит гүн (бэйс) Галсанжав		Баруун амбаны хошуу	Дархан бэйс Балдандорж	
Мээрэнгийн хошуу	Зүтгэлт бэйс Цагаанбилиг		Хөх мончогийн (Шар даагийн) хошуу	Ёст гүн Очиржав	*
Цагаан (Ак) соёны хошуу	Этэй гүн Төрбат	*	Дөнхөр хошхуу	Саруул гүн Гомбожав	
Хар (Улаан) соёны хошуу	Зоригт гүн Сандунжав (Sangdungjab)	*			

(“*” тавьсан нь тувагаар ярьдаг хүмүүс зонхилсон хошуу)

Ж.Цэвээн (Ceveng 1934) Алтайн урианхай нарыг Хөвсгөл нуур ба Тагна урианхайчуудтай яс угсаа нэгтэй гэж үзэж байсан бол сүүлийн үед л тэдний ярьдаг хэлээр “монгол урианхай”, “тува урианхай” гэж хоёр хуваадаг болсон юм. 1980 онд бол Бадамхатан (1980: 30) “Ардын хувьсгалаас өмнө монгол орон нь олон үндэстний бус боловч 20 шахам монгол удмын ястан, мөн казах

(11000), Алтайн урианхай (тува, мончоого нийлсэн) зэрэг түрэг угсааны ястан нарыг багтаасан улс байв” гэж бичиж байсан. Монгол урианхайчууд монгол хэлний ойрад аялгуугаар, тува урианхайчууд түрэг хэлнүүдийн нэг болох тувагаар ярьдаг. Зарим угсаатны судлалын зохиолд Алтайн урианхайн долоон хошууны бүтцийг буруу бичсэн билээ (жишээ нь Бадамхатан 1996; Очир 1993). Тувагаар ярьдаг мончог, хар цагаан соёны гурван хошууг зүүн гарт багтааж баруун гарын гурван хошууг тэр чигээрээ монгол урианхайн хошуу болгосон юм.

Харин үнэндээ бол монгол урианхай болох Мэйрэнгийн хошуу (Зүтгэлт гүнгийн хошуу) нь зүүн гарт, мончог хошуу нь баруун гарт багтаж явдаг байсан. Энэ нь “улс төрийн нэгж нь соёл буюу угсаатны нэгжтэй нийцэх ёстой” гэж Gellner (1983) бичсэн “nationalism”-ийн ухамсар буюу угсаатны онол нөлөөлснөөр хэл нэгтэй хүмүүс нэг гарт багтах ёстой гэж бодсоноос болсон хэрэг гэж болно². Дээр дурдсанаар тувагаар ярьдаг хүмүүс зонхилсон хошуун дотор монголоор ярьдаг хүмүүс байж болох ба монголоор ярьдаг хошуун дотор тувагаар ярьдаг хүмүүс байж болох юм. Мөн угаасаа холимог бүтэцтэй болохоор монголжисон тувачууд, туважисан монголчууд гэж ялгах бас л дэмий боино.

Иймээс Алтайн урианхайн жишээ нь бүлэг хүмүүсийг угсаатан, ястаны үүднээс үзэх угсаатны зүйн арга барил хязгаарлалттай гэдгийг харуулж байна.

2. Социалист угсаатны явц дахь Алтайн Урианхайчууд

Алтайн урианхайчуудыг “ястан” болгон социалист Монгол үндэстэн-улсыг (nation-state) байгуулах үйл ажиллагаанд хамруулан дайчлах бодлогын бодит илэрхийлэл бол 1930 оны 7-р сард Бага Ястны Зөвлөлийг байгуулсан явдал мөн. Тухайн үеийн баруун монголын байдал тогтворгүй, Төгсбуянт, Улаангом, Бодончийн хүрээний лам нар бослого гаргасан. Алтайн урианхайчууд Алтайг давж Шинжиан руу бөөнөөр дүрвэсэн. Иймд тухайн үеийн баруун монголын улс төр-нийгмийн байдлыг “Бага хурлын тэргүүлэгчдийн дэргэдэх үндэс угсааны явдлын зөвлөлийг байгуулах тухай бага хуралын тэргүүлэгчдийн тогтоол”-д ингэж тэмдэглэсэн юм. Үүнд:

“Үүний урьд аль нь ч үндэс угсааны хар шар феодал ба баячууд нь хувьсгал гарахын урд өөр өөрийн эдлэж байсан эрхийг хэрэглэж жинхэнэ ардыг мөлжисөөр ирсэн ба бага буурай үндэстэний жинхэнэ ардууд өөр өөрийн улсын феодал ба баячууд хийгээд нөгөө хүчирхэг их улсын түшмэд нарын давхар мөлжигдөлийг эдлэж байсны улмаас бага буурай үндэстэний жинхэнэ ардууд халхчуудын жинхэнэ ардуудаас илүү хоосорч улс төр ба эрдэм боловсролын талаар туйлын их хоцрогджээ” гэж дүгнэжээ.

(egün-ü urid alincu ündüsü ugsay-a-u qara sira piodal ba, bayacad anu qubisqal yaraqy-yin urid öber öber-ün edleju bayıysan erke-i keregleju jingkini arad-i möljigseger iregsen ba, bay-a bayurai üngdüsüten-ü jingkini arad-ud öber öber-ün ulus-un feodal ba, bayacad kiged, nöğüge kücürkeg yeke ulus-un tüsımed narun dabqar möljigdel-i edleju bayıysan-u ulam-aca bay-a bayurai üngdüsüten-ü jingkini arad-ud qalqacad-un jingkini arad-ud-aca ilegüü qoqusurcu ulus törü ba, erdem bolbasural-un tal-a-bar tuyıl-un yeke qocuraydajuqi) (МУТА /Монгол Улсын Төв Архив/: 11-1-228).

Энэхүү дүгнэлт нь социалист угсаатны онолын анги ба үндэстний харилцааны хүрээнд тухайн бүс нутгийн улс төр-нийгмийн байдлыг авч үзээд шинэ улс байгуулахад тулгарсан бэрхшээлийн шалтгааныг “давхар мөлжигдөл”-ийн улмаас их “хоосорч улс төр ба эрдэм боловсролын талаар туйлын их хоцрогдсон” бага үндэстэний байдалд байгаа гэж тайлбарласан юм. Иймээс “тэдгээрийн эдийн засаг ба эрдэм боловсролыг бататган хөгжүүлэх нь чухал болох учир” Бага хурлын тэргүүлэгчдийн дэргэдэх Үндэс угсааны явдлын зөвлөлийг (Бага ястны зөвлөл) байгуулахаар тогтоосон юм.

Үндэстэн, ястаныг улс төрийн үйл хэрэгт тэгш эрхтэй оруулах, эрдэм боловсролыг хөгжүүлэх явдал бол нөгөө талаас үндэстэн ястан хоорондоо ижилсэх, уусан шингэх явц мөн билээ. Харин Баян-Өлгий аймгийн урианхайчуудын хувьд халх руу бус, казак руу ижилсэх, уусан шингэх явцад орох болсон юм.

1940 оны 6 дугаар сард хуралдсан улсын 8 дугаар их хурлын тогтоолд “казак урианхайн ард түмний хүсэлт эрэлтийн ёсоор” Ховд аймгийг хувааж казак урианхай үндэстнийг нэгэн аймаг болгох шийдвэрийг гаргасан (Минис, Сарай 1960: 65) бөгөөд мөн “1940 оны 8-р сарын 17-нд казак урианхайн ард түмнээр бүрдэл болсон 7000 орчим өрх, 32000 орчим хүн, 0,1 сая орчим толгой малтай 10 сумтай Баян-Өлгий аймгийг байгуулжээ” (Бадамхатан 1980: 34).

Энэхүү явдлыг угсаатны хөгжлийн онолын хувьд “халх, казак ястны хэл, соёлд тулгуурлан бусад ястнууд эдгээр хоёр ястантай ижилсэх, уусах чиглэлээр хөгжин хоёр том угсаатны нэгдэл үүсэн бүрэлдэн тогтож байна” гэж тайлбарласан байна (Бадамхатан 1973: 20). Өөрөөр хэлбэл Баян-Өлгий аймаг байгуулагдсан нь “социалист монгол үндэстэн” (Бадамхатан 1980: 34) тогтохоос өмнөх шат дахь казак дэд-үндэстэн (sub-nation) бүрэлдүүлэх нөхцлийг бий болгох явдал гэж дүгнэж болох юм (Зураг 1).


Тэгэхэд дийлэнх урианхайчууд казахуудтэй хэл, соёлын нийтлэг шинж бараг байхгүй байсан. Үүний нэг жишээ нь Бага хурлын гишүүн Тэвэгт 1927 оны 7 сарын 27-нд Бага хурлын тэргүүлэгчдэд өөрийн Алтайн урианхайн Итгэмжит гүнгийн хошууны байдлын тухай:

“Манай монголын харьяат казахын Хошаг, Шыбыр-Айгыр, Шерүүш эдгээр гурван хошууны ардууд ба эрх баригчид нь, басхүү Акамудийн(?) хошуу эл дөрвөн хошуунд ноднин намрын сард туйлын зохих газраас тусгай нутгийг зааж ялган салгаж хуваарлан нутаг олгож тус тусыг тохниулсан билээ. Тэрхүү олгосон газар нутгийг ойшоохгүй хойш тавьж бусдын өвөлжөө бууц элдэвийг түрэмгийлэн эзэмдэж эгнээ урианхайн аль өн шимтэй өвс бууцыг шууд дайчлан хэрэглэсээр ирсэндээ дадаж эрэмшин хэтрээд өөр өөрсдийн урдын муу суртал дадлыг өөгширтэл(?) баримтлаж урианхай ардыг малчилан үзэх байдал илэрхий бүхийг бэлхэнээ зохих газраас толилон буй хэрэг нь алинийг тооцож барахгүй билээ. Бас мөн казахийн баяд этгээд нар хурдны морь унаж хурц зэвсгийг барилан авч бидний хөдөөгийн бүдүүлэг буурай ардуудын атал хогшил хөрөнгийг шууд дээрэмлэн хулган аваачиж бүрэлгэн самшигдуулах нь ер тасралтгүйн дээр нэн ялангуяа агаараар нисэх жигүүртэн шувуун бүргэд хэмээгчийг тавиж Алтай уулын үстэй ан үнэг араатаныг бариулан авч хядан сөнөөх ань үлэмж болох бөгөөд мөн манай монголын урдын заншил болсон овоо тайлга бүхүй цаазласан газруудын ан гөрөөсийг алж авах нь хэтэрхий болсоноос үл барам, тэрхүү үнэг ангийн үндэс үрийг таслахад хүрсэн нэгэн зүйлийн хорлол бүхий хэрэг буй....”

(man-u mongγul-un qariyatu qasay-un qovasay ciberiayar cirüüci edeger yurban qosiyun-u arad-ud ba erke bariycid anu, basaku aqamudi-yin qosiyun ele dörben qosiyun-dur nidunun namur-un saradu tuyil-un jokiqu yajaraca tusqai nutuy-i jiyaju ilyan salγaju qubiyarilan nutuy olγayulju tustus-yi toquniγuluγsan bölüge. terekü olγuγsan yajar nutuy-yi öisiyekü ügei qoyisi talbiju busud-un ebüljiy-e bayuca eldeb-yi türimegeyilen ejemdejü enggenei uriyangqai-yin ali öng sim ebüsü bayuca-yi siγud dayicilan kereglegseger iregsen dayan dadaju erimsin ketereged öber öbersed-ün urid-yin mayu surtal dadal-a-yi öngsirtel-e? barimtalju uriyanqai arad-ud-yi malcilan üjekü bayidal ilerkei бүкүи-yi beleken-e jokiqu yajaraca tolilan bui kereg anu alin-i toyucaju baruqu bile. basa mön qasay-un bayad eteged nar qurduni mori unaju qurca jebseg-i barilan abcu biden-ü ködüge-yin bedegülig bayurai arad-ud-un atal qongsil körüngge-yi siγud degeremlen qulγun abciqaju бүрилген samsiydayulqu anu yerü tasaralta ügei-yin deger-e neng ilangγuy-a ayar-iyar niskü jigürten sibayun bürgüd kemegci-yi talbiju altai ayula-yin üsütei ang ünege ariyatan-i bariγulun abcu kidun sönügekü anu ülemji bolqu böged mön man-u mongγul-un urid-yin jangsil boluγsan obuγ-a tayily-a бүкүи cayaγilayγan yajar-ud-un ang göregesü-yi alaju abaqu anu keterkei boluγsan-aca ülü baram terekü ünege ang-un ündüsün üri-yi tasulaqu-dur kürüγsen nigen jüil-ün qourlal бүкүи kereg bui) (МҮТА: 11-1-119) гэж мэдүүлсэн байна. Энэ мэдээ нь казах, урианахайн хооронд зан заншилын зөрчил байсан төдийгүй чадал тэнхээний хувьд ч гэсэн нэлээн ялгаа байсныг харуулж байна.

Зураг 1.

Монгол үндэстний хөгжлийн схем



Cf. Soviet Nation, 中華民族

1911 онд тусгаар тогтнолоо тунхагласан монголчуудыг үзэн яддаг Шинжаианы захирагч Ян Зэншин буу зэвсгийг урианхайчуудаас хурааж байхад казахуудад тарааж нийлүүлдэг байсан (Lattimore 1950: 55, 137). Анх 1880-ад оноос Алтайд ирээд урианхайчуудын бэлчээрийг ноёдод нь хөлс өгөөд ашиглаж байсан казахууд Алтайн монголчуудыг халхчуудаас салгаж хөндийлөх Янгийн бодлогыг завшиж урианхайчуудын Алтай дахь нутгийг шууд булааж авдаг болсон (Benson 1998: 62). Энэ хүч чадлын ялгаа нь 1930-аад оны эхээр Монгол-Шинжианы хил хаагдсанаас хойш мөн хэвээрээ байсан байж магадгүй³.

Нөгөөтэйгүүр тухайн цаг үеийн байдал тус аймгийг байгуулахад нөлөөлсөн болно. Өнөөгийн Шинжаангийн Алтай муж бол Алтайн урианхайчуудын ууган нутаг мөн бөгөөд Хятадад алдагдсан энэ нутгийг эргүүлэн авах хүсэлт Алтай урианхайгаас их, бага хуралд оролцсон төлөөлөгчид удаа дараалан илтгэж байсан юм. Энэ нь тэд нарыг Алтай давж Шинжаан руу дүрвэх хамгийн гол шалтгаан болсон. 1924 оны 11-р сарын 22-нд БНМАУ-ын анхдугаар их хурал дээр урианхайн төлөөлөгч Тэвэгт аман илтгэл тавьсанаас гадна “Алтай урианхайн Дархан бэйсийн хошууны ард олон нийтээс Улсын их хуралд хуудсаар” илтгэсэн нь:

“Манай урианхайн нутгын баруун хойт хязгаар Оросын нутагт зах нийлсэн уудам их бөгөөд дэлхийн баялаг үлэмж боловч цөм хятад казах этгээд эзэрхэж ашиглан бүхий учрыг илтгэж тэрхүү шим өнтэй нутаг газрыг дотоодод хамгаалан авч ядуу урианхайн хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндэсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлэхийг үнэхээр эрмэлзэн хүсмүй.”

(man-u uriyangqai-yin nutuγ-un barayun qoyitu kijayar orus-un nutuγ-tu jiq-a neyilegsen ayudam yeke böged delkei-yin bayalay ülemji bolbacu cöm kitad qasay edeged ejerkeju asiylan бүкүй uciri iledgejü terekü sim-e öngtei nutuγ yajar-i dotuγadu-du qamγalan abcu yadayu uriyangqai-yin kedün qosiyun-u arad-uud-i kümüjigülün nutuγ üngdüsü-ber бүрин бүтүн бolyaju tengkerigülkü-yi üneker ermелjen күсүмүй.) (МУТА: 2-266-1)

1913 онд Богд хааны цэрэг Ховд хотыг чөлөөлсөний дараа Алтайн Шар сүм рүү явсан боловч замын дундаас буцаж ирсэн. Мөн Чойбалсан бас Алтайг авах эрмэлзэлтэй байсан бололтой. 1942 онд Шинжианы эрх баригч Шен Шицайг Зөвлөлтөөс Гоминданд урвасны дараа Оспанаар Алтайг авхуулах санаатай байсан (Болд, Туяа 2011). Урианхайчууд өөрийн ууган нутаг дэвсгэрээ эргүүлэн авах гэсэн бол Чойбалсан Монголын нутаг дэвсгэрийг өргөтөх гэсэн санаатай байсан юм. Гэвч урианхайчууд хүч муутэй буурай улс байсан бол тэд нартай холилдон суурьшсан казахууд хүчирхэг, Шинжианы улс төрийн байдалд ч гэсэн нөлөөтэй байсан. Иймээс Монголын төр засгийн хувьд казахууд урианхайчуудаас хамаагүй чухал байсан билээ.

Дүгнэлт

Алтайн урианхайчууд уг нь “ястан” гэдэг нэр томъёоны заасан шиг яс (эцгийн талын удам угсаа) эсвэл гарал үүсэл нэгтэй бүлэг хүмүүс биш, харин нэг засаг захиргааны нэгжид багтан явдаг бүлэг хүмүүс байсан. Гэтэл тэднийг “олон үндэстний ... Зөвлөлт Холбоот Улсын баялаг туршлагад түшиглэн” (Бадамхатан 1980: 31) “ястан” болгосоноор ижилсэх, уусан шингэх “угсаатны хөгжил”-ийн явц, ялангуяа 1940 онд байгуулагдсан Баян-Өлгий аймагт багтсан Алтайн урианхайчуудын хувьд казахуудтай ижилсэх, уусан шингэх явцанд зайлшгүй оруулсан юм. Социалист угсаатны зүй ястнуудыг илрүүлж, ялган хувааж (урианхайн хувьд түрк гаралтай гэж), угсаатны хөгжилийн онолд баримтлаж ямар хүмүүстэй нийлэх ёстойг (Баян-Өлгий аймгийн урианхайчуудын хувьд казахуудтай) зааж, социалист үндэстэн-улс (nation-state) байгуулахад, мөн баруун хязгаарыг тохинуулахад, шинжлэх ухааны үндэслэл өгсөн юм. 20-р зууны эхний хагаст Алтайн урианхайчуудын хувь заяанд болсон улс төр, нийгмийн томхон үйл явдал бол угсаатны хөгжилийн онолтой уялдуулан өрнөсөн юм.

ЗҮҮЛТ

¹ Алтан-Оргилийн өгүүллийн энэ хэсгийг бүтнээр иш татвал дараах болно. Үүнд: “概括起来讲：第一、确实从森林兀良合或草原兀良合演变过来并由原真正的兀良合人构成的部落，如绰罗斯、塔崩、鄂尔多斯、额鲁特、小额鲁特、杜尔伯特、喀喇沁、准噶尔等。第二、因为统治者是兀良合部人而一度被称为兀良合的部落，如蒙古勒津、阿尔泰·兀良罕、唐努·兀良罕等。第三、由于政治上的从属关系或者荣誉的追求而被命名和冒名的兀良合部，如原秃绵·乞儿思吉之各部以及巴尔浑、不里牙惕等” (金峰1990: 122-123). Энд аймгуудийн нэрийг дурдсан байдаг.

² Мөн Бадамхатан зөвхөн Ховд аймгийн Мөнххайрхан сумын Нанзад өвгөнөөс авсан ярилцлагыг үндэслэсэн.

³ Шинжианы хувьд Шен Шицай 1930-аад оны сүүлээр болоод Алтай аймгийн казахуудаас буу зэвсэг хураах арга хэмжээ явуулсан (Болд, Туяа 2011: 82).

НОМ ЗҮЙ

- Алтан-Оргил (金峰1990) 「再论兀良合部落的变迁」阿拉善盟项公署·内蒙古师范大学合编『卫拉特史论文集』内蒙古师大学报哲社版 1990 年第三期专号, pp.122-136.
- Anderson, B. (1991) *Imagined Communities: Reflections on the Origin and Spread of Nationalism*. Revised Edition. London and New York: Verso.
- Benson, Linda (1998) *China's Last Nomads: The History and Culture of China's Kazaks*. M.E. Sharpe, Inc.
- Бадамхатан, С. (1973) БНМАУ-ын үндэстний ба угсаатны хөгжлийн асуудалд. *Studia Historica* 9(14). УБ.
- Бадамхатан, С. (1980) МАХН-ын үндэстний асуудлаархи бодлого (1921-1940). *Studia Historica* 15(4). УБ.
- Бадамхатан, С. (1996) *Ойрадын угсаатны зүй*, Монголын угсаатны зүй, Дэд боть. УБ.
- Болд, Б., Туяа, Б. (2011) *Оспан хэн байв- Монгол баримт юу өгүүлэв*. УБ.
- Gellner, A. (1983) *Nations and Nationalism*. Cornell University Press.
- Lattimore, O. (1950; repr. 1975) *Pivot of Asia.: Sinkiang and the Inner Asian Frontiers of China and Russia*. AMS Press.
- Минис, А., Сарнай, А. (1960) БНМАУ Баян-Өлгий аймгийн казах ард түмний түүхээс. УБ.
- Очир, А. (1993) *Монголын Ойрадуудын түүхийн товч*. УБ.
- Ceveng, J. (1934) *Darqad, kübsügül nayur-un uriyangqai, dörbed, qotung, bayad, ögeled, mingad, jaqacin, torj ud, qoγ ud, caqar, dariγ angγ-a, altai-yin uriyangqai, qasaγ, qatniγan nar-un γarul ündüsü bayidal-un ögülel*. Bүgde nayiramdaqu mongγul arad ulus-un sinjileküi uqayan-u küriyeleng. (Ts. Zhamtsarano (1979) *Ethnography and Geography of the Darkhat and Other Mongolian Minorities*, with a Mongolian-English Glossary by John R. Krueger. The Mongolia Society Special Papers, Issue Eight. The Mongolia Society.)